



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 30 өдөр

Дугаар A/178

Улаанбаатар хот

Дүүргийн 5 дугаар хорооны Моносын 3 дугаар
гудамжны гэрэлтүүлгийн ажлын барьцаа
хөрөнгө чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2015 онд санхүүжигдсэн Дүүргийн 5 дугаар хорооны Моносын 3 дугаар гудамжны гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэсэн “Их хотын гэрэл” ХХК-ийн ажлын барьцаа 2 029 806 /хоёр сая хоёр хорин есөн мянга найман зуун зургаан/ төгрөгийг барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөхийг Тамгын газар /Б.Амартүвшин/-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд бүтэц, хот төлөвлөлт хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Т.Батцогтод үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА